



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ,
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ

/Газрын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 26

Дугаар 35-00/05

Улаанбаатар хот

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл:

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд Газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн нийтийн албан тушаалтны асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, хохирлыг нэхэмжлэх ажлын хүрээнд Налайх дүүргийн Засаг даргын 2020-2025 онуудад газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан байдлыг хянаж шалгах Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Хаягжуулалтын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг тодорхойлоход хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектийн нэр:

2.1. Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Газар зохион байгуулалтын алба тус тус хамрагдана.

2.2. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хадгалагдаж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон дүүргийн Засаг даргын тамгын газарт хадгалагдаж буй засаг даргын захирамжуудыг газар зохион байгуулалтын албанд байгаа газар зохион байгуулалтын төлөвлөгөө, захирамжуудтай тулгах.

1535080010

2.3. Налайх дүүргийн Засаг даргын 2020-2025 онуудад газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх сүүлийн 6 жилд гарсан захирамжийг хянаж, нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системтэй тулгалт хийж, дүн шинжилгээ хийх.

2.4. Эрх бүхий Засаг даргын шийдвэрээр 2020-2025 онуудад газар өмчилж, эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу газар олголт хийсэн эсэх.

2.5. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын дагуу дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгосон эсэх, мөн хуульд заасан хэмжээг баримталсан эсэх.

2.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан эсэх.

2.7. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон хуулийн этгээдэд 2020-2025 онд газар эзэмшүүлж, ашиглуулсан байдлыг шалгах, нягтлах, мөн шийдвэр гаргахад хуулийн этгээдийн хэлбэр, төрөл (гадаадын хөрөнгө оруулалттай байсан эсэх) түүнээс хойш өөрчлөлт орсон эсэх.

2.8. Нэгж талбарын хувийн хэрэг шалгах.

2.9. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газар эзэмших, өмчлөх эрх зөрчигдсөн, удаа дараа төрийн байгууллагад гомдол гаргаад шийдвэрлэгдээгүй өргөдөл гомдлыг шалгах.

2.10. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системд бүртгэгдсэн цахим өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийх.

Гурав. Шалгалтын төрөл, арга:

3.1 Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх.

3.2 Төлөвлөгөөт бус шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийх.

3.3 Хяналт шалгалт хийхдээ шаардлагатай баримт бичиг, холбогдох судалгаа, мэдээлэл, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийг шалгуулагч байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулах, хуулбар үнэн даруулах зэргээр нотлох баримтын шаардлага хангуулан хуулбарлан авна.

Дөрөв. Шалгалт хийх бүрэлдэхүүн:

4.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Түвшинбат ахалж, Газар, геодези, зураг зүйн улсын (ахлах) байцаагч Г.Энхжин, Г.Энхтулга, Б.Туул, Т.Эрдэнэболор, Ц.Пагмадулам, Э.Юмжирмаа, Э.Амаржаргал нар хийж гүйцэтгэнэ.

4.2. Шаардлагатай тохиолдолд бусад хэлтсийн холбогдох (ахлах) мэргэжилтэнг татан оролцуулж болно.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

5.1. Шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалтын дүнг танилцуулах:

6.1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын танилцуулгыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ын 25 дахь хэсэгт заасны дагуу нэгтгэж 2026 оны 04 дүгээр сарын 02-ны дотор Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана.

__оОо__